



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2018 оны 03 сарын 06 өдөр

Дугаар 44

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө олж авах зөвшөөрөл
олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 24 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 3.3 дахь заалт, Удирдах зөвлөлийн 2015 оны 09, 2017 оны 20 дугаар тогтоол, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны 2015 оны 2/6020, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны 2018 оны 11/719 дүгээр албан бичгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Шинжлэх Ухаан, Технологийн Их Сургуульд өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр, 2,000,000,000.00 (хоёр тэрбум) төгрөгт багтаан үндсэн хөрөнгө (Барилга, Архитектурын Сургуулийн барилгын нэгдсэн судалгааны лабораторийн барилга) олж авахыг зөвшөөрсүгэй.

2. Шинжлэх Ухаан, Технологийн Их Сургуулийн захирал Б.Очирбатад дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Барилга, Архитектурын Сургуулийн барилгын нэгдсэн судалгааны лабораторийн барилгын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ц.НЯМ-ОСОР

Э.ЭРДЭНЭХИШИГ

D:\Huraldaanii material\2018.03.06\togtool\04docx

0001493